58

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Л.МӨНХБАЯСГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.12.18 № ХЗГ/2601

танай _____-ны №_____-т

Асуултын хариу хүргүүлэх тухай

"Цагаандэл уул-Өлзий" боомтын бүтээн байгуулалтын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуултын хариуг холбогдох Засгийн газрын гишүүдээс бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт 29 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ

000245025298

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

МОНГОЛ УЛС
БООМТЫН СЭРГЭЛТИЙН
УНДЭСНИЙ ХОРОО

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (976-51) 26 26 11
Цахим шуудан: info@nsrc.gov.mn

2024.12.12 № 01/1318

танай 2024.12.02 -ны № ХЗГ/2379 т

Хариу хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн Цагаандэл-Уул-Өлзий боомтын бүтээн байгуулалтын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн асуултын хариуг хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газраас Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтын талаар дараах шийдвэрүүд гарсан. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн "Хилийн боомтын талаар авах арга хэмжээний тухай" 46 дугаар тогтоолд "***Монгол, Хятадын улсын хилийн дагуу Монгол Улсын талаас Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутаг Цагаан дэл уулын чиглэлд, Хятадын талаас БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн Альшаа зүүн хошууны нутаг Өлзий уулын чиглэлээр хоёр талын зорчигч, ачаа тээврийн "Цагаан дэл уул–Өлзий" байнгын ажиллагаатай авто замын боомт шинээр байгуулахыг зөвшөөрсүгэй***" гэж;
2. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн худалдааны тэмдэглэлийн 2.9 дэх хэсэгт "***БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж байгаа хилийн Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтад шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материалыг хятадын талаас татах түр гарцыг зохих журмын дагуу нээж, сар бүрийн ажлын 10 хоног ажиллуулах талаар Хятадын талтай дипломат шугамаар тохиролцох, хэрэгжүүлэх, чиглэлээр ажиллахыг Гадаад харилцааны сайд, Сангийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд нарт даалгасугай***" гэж;
3. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр албан даалгаварт "***Цагаандэл-Уул боомтын үндсэн болон нэмэлт байгууламжийн төвлөрсөн цахилгаан хангамжийг дотоодын эх үүсвэрээс хангаж, дулаан хангамжийн нам даралтын зуухыг төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг үе шаттай зохион байгуулах арга хэмжээ авах***" гэж;
4. Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Өмнөговь аймагт

ажилласан дүнгийн талаар Засгийн газрын гишүүдэд танилцуулсаны дагуу батлагдсан "Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Өмнөговь аймагт ажиллахдаа өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 7 дугаарт "***Хилийн Цагаандэл-Уул – Өлзий боомтын асуудлыг Өмнийн говийн хөгжлийн зөвлөлөөр хэлэлцэн санал, дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулах***" гэж;

5. Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дүгээр албан даалгаварын 1.4.2.-т "***Цагаандэл-Уулын жишиг боомт байгуулах***" гэж;
6. Засгийн газар хөгжлийн тулгамдсан асуудал, тулгарч байгаа сорилтуудыг илүү хурдан, үр дүнтэй шийдвэрлэх, бүрэн эрхийнхээ хугацаанд бүтээлчээр, тогтвортой хамтран ажиллах зорилгоор Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын хооронд байгуулсан "ХУРДТАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ" хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр Улсын Их Хурлаар батлагдсантай холбогдуулан 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай Монгол Улсын Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгаварын 8.1-д "***Цагаандэл-Уул боомтын үйл ажиллагааг эхлүүлэх***" гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Засгийн газраас гарсан дээрх шийдвэрүүдийн хүрээнд:

1. Цагаандэл-Уул – Өлзий боомтын бүтээн байгуулалттай холбоотойгоор БНХАУ-ын талтай байгуулсан гэрээ, хэлэлцээр, холбогдох баримт бичгийн талаар мэдээлэл, бүтээн байгуулалтын явц, олгосон санхүүжилтийн дүнгийн талаар:

   "Монгол, Хятадын хилд шинээр байгуулах Цагаандэл Уул-Өлзий боомтын хамтарсан ажлын хэсгийн Цагаандэл уул боомтын шалган нэвтрүүлэх барилга байгууламж, дэд бүтцийг буцалтгүй тусламжаар бүтээн байгуулах тухай Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон Бүгд найрамдах Хятад ард улсын Өвөр Монголын өөртөө засах орны боомтын алба хооронд 2019 оны 6 дугаар сарын 25-ны өдөр гэрээ байгуулагдсан.Төслийн хүрээнд Цагаандэл уул боомтод хашаа барих ажил хийгдсэн бөгөөд өөр бүтээн байгуулалтын барилга угсралтын ажил одоогоор эхлээгүй байна. (Санхүүжилтийн мэдээллийг хавсралт №1-д тусгав.)

2. Боомтын ТЭЗҮ, Байгаль орчны нарийвчилсан төлөвлөгөө, үнэлгээний тайлан, усны менежментийн төлөвлөгөөний талаар, үүнтэй холбоотой байгуулсан бүх гэрээ, хэлцэлийн дэлгэрэнгүй мэдээллийн талаар:

   Цагаандэл уул боомтын техник эдийн засгийн үндэслэл боловсруулах гэрээт ажил бүрэн дууссан, Хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах гэрээт ажил 92 хувьтай, Байгаль орчны үнэлгээний гэрээт ажил 90 хувьтай, нарийвчилсан зураг төсөл боловсруулах гэрээт ажил 99 хувьтай байна. 2022 оны 5 дугаар сард Усны газраас "Усны эрэл хайгуулын судалгаа"-ны ажил хийгдсэн. Тус тайланд боомтоос зүүн хойно 4.5 км-т "Мухар таг"-ын аман дахь хоёр цооногоос эхний ээлжийн усны хэрэглээг хангах боломжтой гэж гарсан байна. Цаашид өсөн нэмэгдэх усны хэрэглээг хангахын тулд нэмэлт хайгуулын ажил хийх шаардлагатай талаар тус тайланд тусгажээ.

   (Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт№1 болон бусад холбогдох мэдээлэлд тусгав.)

3. Монгол улсын Ерөнхий сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр албан даалгаварт " Цагаандэл-Уул боомтын үндсэн болон нэмэлт байгууламжийн төвлөрсөн цахилгаан хангамжийг дотоодын эх үүсвэрээс хангаж, дулаан хангамжийн нам даралтын зуухыг төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг үе шаттай зохион байгуулах арга хэмжээ авах" гэж заасантай холбогдуулан боомтын байгууламжийг цахилгаан хангамжтай холбох болон усаар хангах хөрөнгө оруулалтын эх үүсвэр, холбогдох тайлан судалгаа, ажлын гүйцэтгэл, хариуцаж буй хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний талаар:

   Боомтын цахилгааны нийт хэрэглээ нь 2463 кВа байх ба тус бүр нь 2*800 кВа чадалтай 3 иж бүрдэл, 1*63 кВа чадалтай 1 иж бүрдэл трансформаторын дэд өртөө барих бөгөөд энэхүү хэрэглээг БНХАУ-ын Өлзий боомт талаас импортоор 10 кВ-ын цахилаан дамжуулах агаарын шугамаас хангахаар техникийн нөхцөл нь гарсан байна. (ЭХЯ-аас олгосон Техникийн нөхцөлийг хавсаргав)
   Боомтын дулаан хангамж нь тус бүр нь 1.6 мВт-ын хүчин чадалтай 3 усан халаалтын зуух байхаар нарийвчилсан зураг төсөлд тусгагдсан байна.

4. Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтын хүрээнд байгуулсан зөвлөх үйлчилгээний, ажил гүйцэтгэх болон бүх гэрээ, тэдгээрийн нэмэлт өөрчлөлтийн талаар:

   2023 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн №ХХДБТ/20230510/03 тоот Монгол Улсын сангийн яамны "Хөгжлийн хөтөч дэд бүтэц" төсөл БНХАУ-ын ӨМӨЗО-ны Өлзий боомтын захиргаа, Өвөр Монгол Өлзий боомт удирдлага менежмент компани болон "Идеал групп" ХХК хооронд Өмнөговь аймгийн хүрмэн сум дахь хилийн цагаандэл уул боомт орчмын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ,

   2023 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн №ХХДБТ/20230510/03-1 тоот Монгол Улсын сангийн яамны "Хөгжлийн хөтөч дэд бүтэц" төсөл БНХАУ-ын ӨМӨЗО-ны Өлзий боомтын захиргаа, Өвөр Монгол Өлзий боомт удирдлага менежмент компани болон "Идеал групп" ХХК хооронд Өмнөговь аймгийн хүрмэн сум дахь хилийн цагаандэл уул боомт орчмын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээнд өөрчлөлт оруулах тухай гэрээ,

   2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн №ХХДБТ/20230407/01 тоот Монгол Улсын сангийн яамны "Хөгжлийн хөтөч дэд бүтэц" төсөл БНХАУ-ын ӨМӨЗО-ны Өлзий боомтын захиргаа, Өвөр Монгол Өлзий боомт удирдлага менежмент компани болон "Эн Би Си Си" ХХК хооронд Цагаандэл-Уул боомтын техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчны үнэлгээ боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ,

   2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн №ХХДБТ/20230407/02 тоот Монгол Улсын сангийн яамны "Хөгжлийн хөтөч дэд бүтэц" төсөл БНХАУ-ын ӨМӨЗО-ны Өлзий боомтын захиргаа, Өвөр Монгол Өлзий боомт удирдлага менежмент компани болон "Өрнөл Проект" ХХК хооронд Цагаандэл-Уул боомтын нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ,

   2023 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн №ХХДБТ/20230407/02-1 тоот Монгол Улсын сангийн яамны "Хөгжлийн хөтөч дэд бүтэц" төсөл БНХАУ-ын ӨМӨЗО-ны Өлзий боомтын захиргаа, Өвөр Монгол Өлзий боомт удирдлага менежмент компани болон "Өрнөл Проект" ХХК хооронд Цагаандэл-Уул боомтын нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээнд өөрчлөлт оруулах гэрээ,

2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн №ХХДБТ/20230407/02-3 тоот Монгол Улсын сангийн яамны "Хөгжлийн хөтөч дэд бүтэц" төсөл БНХАУ-ын ӨМӨЗО-ны Өлзий боомтын захиргаа, Өвөр Монгол Өлзий боомт удирдлага менежмент компани болон "Өрнөл Проект" ХХК хооронд Цагаандэл-Уул боомтын нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээнд өөрчлөлт оруулах гэрээ,

2023 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн №ХХДБТ/20230814 тоот "Хөгжлийн хөтөч дэд бүтэц" төсөл хэрэгжүүлэх нэгж болон БХЯ-ны "Барилга захиалагчийн алба" ТӨААҮГ хооронд Өмнөговь аймаг, Хүрмэн сум "Цагаандэл-Уул" хилийн боомтын гадна хашааны барилга угсралтын ажилд захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээ,

2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн №ХХДБТ/20230815 тоот "Хөгжлийн хөтөч дэд бүтэц" төсөл хэрэгжүүлэх нэгж болон БХЯ-ны "Барилга захиалагчийн алба" ТӨААҮГ хооронд Өмнөговь аймаг, Хүрмэн сум "Цагаандэл-Уул" хилийн боомтын гадна хашааны барилга угсралтын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт хийх гэрээ,

2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн №ХХДБТ/20230810 тоот Монгол Улсын сангийн яамны "Хөгжлийн хөтөч дэд бүтэц" төсөл БНХАУ-ын ӨМӨЗО-ны Өлзий боомтын захиргаа, Өвөр Монгол Өлзий боомт удирдлага менежмент компани болон "Жунмэй Инженеринг" ХХК хооронд Өмнөговь аймаг, Хүрмэн сум "Цагаандэл-Уул" хилийн боомтын гадна хашааны барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ,

2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн №ХХДБТ/20241128/01 тоот Монгол Улсын сангийн яамны "Хөгжлийн хөтөч дэд бүтэц" төсөл БНХАУ-ын ӨМӨЗО-ны Өлзий боомтын захиргаа, Өвөр Монгол Өлзий боомт удирдлага менежмент компани болон "Жунмэй Инженеринг" групп, "Жунмэй Инженеринг Групп Монголиа" ХХК хооронд Өмнөговь аймаг, Хүрмэн сум "Цагаандэл-Уул" хилийн боомтын авто зам талбайн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг тус тус байгуулан ажиллаж байна.

5. Өмнийн говийн хөгжлийн зөвлөлийн боомтын асуудлаар хэлэлцсэн санал, дүгнэлтийн талаар:
Өмнийн говийн хөгжлийн зөвлөлийн хурлаар Цагаандэл-Уул боомтын талаар хуралдаагүй болно.

Хавсралт 11 хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН САЙД,
БООМТЫН СЭРГЭЛТИЙН ХИДЭСНИЙ
ХОРООНЫ ДАРГА Б.ТУЛГА

Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны 2024 оны 12 дугаар сарын 12-ний өдрийн 04/1318 тоот албан бичгийн 1 дүгээр хавсралт

Хилийн Цагаандэл-уул боомтын санхүүжилт болон ажлын явцын мэдээлэл

2024 оны 12 сарын 02-ны өдрийн байдлаар

Д/д	Гэрээний нэр, дугаар	Гүйцэтгэгч компанийн нэр	Гэрээ байгуулсан дүн		Нийт санхүүжсэн дүн /юаниар/	Үлдэгдэл /юаниар/	Ажлын явц
			Төгрөг	юань			Хувь
1	Цагаандэл-уул боомтын техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчны үнэлгээ боловсруулах зөвлөх үйлчилгээ. 2023.04.07-ХХДБТ/20230407/01	"Эн Би Си Си" ХХК	445,456,426.80		564,877.70	374,081.38	1. Боомтын Техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ тайлан экспертизээр хянагдаж, магадлалаар баталгаажсан. Захиалагчид 2024 оны 11 сарын 1-ний өдөр хүлээлгэн өгсөн. /Явц 100%/ 2. Байгаль орчны ерөнхий үнэлгээ 2024 оны 04 сарын 09-ний өдөр гарч, нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулагдан дууссан байна. Байгаль орчны нарийвчилсан төлөвлөгөөг Өмнөговь аймгийн Хүрмэн сумын Жанжин багийн хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. /Явц 90%/
2	Өмнөговь аймгийн Хүрмэн сум дахь хилийн Цагаандэл уул боомт орчмын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээ. 2023.05.14- ХХДБТ/20230510/03	"Идеал групп" ХХК	147,635,910.87		249,490.07	60,816.50	Боомт орчмын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын Инженерийн дэд бүтцийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. /Явц 92%/
3	Цагаандэл-уул хилийн боомтын нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ. 2023.04.07- ХХДБТ/20230407/02	"Өрнөлпроект" ХХК	834,713,932.07		1,152,678.16	613,262.79	1.Боомтын авто зам талбайн иж бүрэн зураг төсөл бүрэн хийгдэж дууссан. /Явц 100%/ 2.Боомтын барилга, байгууламж, гадна ИШС, нарийвчилсан зураг төсөл дуусаж БХТ-ийн магадлалаар хянагдаж баталгаажсан. Магадлалын ерөнхий дүгнэлт баталгаажихыг хүлээж байна. /Явц 100%/
4	Цагаандэл-уул хилийн боомтын гадна хашааны барилга угсралтын ажил. 2023.08.10-ХХДБТ/20230810	"Жунмэй инженеринг групп" ХХК		6,547,526.00	5,000,000.00	1,139,108.70	**Ажлын явц 100% хэрэгжиж дууссан.**
5	Цагаандэл-уул хилийн боомтын гадна хашааны барилга угсралтын ажлын зураг төсөл зохиогчийн хяналтын хийх ажил. 2023.08.10-	Өрнөл проект ХХК	28,219,535.00		55,587.71	-	**Ажлын явц 100% хэрэгжиж дууссан.**
6	"Цагаандэл-уул" хилийн боомтын гадна хашааны барилга угсралтын ажлын захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх ажил. 2023.08.10-ХХДБТ/20230814	Батлан хамгаалах яамны "Барилга захиалагчийн алба" ТӨААТҮГ	56,439,071.00		111,179.04	-	**Ажлын явц 100% хэрэгжиж дууссан.**
	Нийт хөрөнгө оруулалт /юаниар/			**114,600,000.00**	**7,133,812.67**	**107,466,187.33**	

МОНГОЛ, ХЯТАДЫН ХИЛД ШИНЭЭР БАЙГУУЛАХ ЦАГААНДЭЛ УУЛ-ӨЛЗИЙ БООМТЫН ХАМТАРСАН АЖЛЫН ХЭСГИЙН ЦАГААНДЭЛ УУЛ БООМТЫН ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ДЭД БҮТЦИЙГ БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖААР БҮТЭЭН БАЙГУУЛАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ӨВӨР МОНГОЛЫН ӨӨРТӨӨ ЗАСАХ ОРНЫ БООМТЫН АЛБА ХООРОНДЫН ГЭРЭЭ

Монгол, Хятадын хилд шинээр байгуулах Цагаандэл уул-Өлзий боомтыг бүтээн байгуулах, нээж ажиллуулах ажлыг эрчимжүүлэхийн тулд Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 46 дугаар тогтоол, "Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай гэрээ", "Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай хэлэлцээр", Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Төрийн зөвлөлөөс Өвөр Монголын Өлзий авто замын боомтыг нээж ажиллагуулхыг зөвшөөрөх тухай" 2016/28 тоот тогтоол зэрэгт үндэслэн эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмын дагуу Монгол, Хятад хоёр талын ажлын хэсэг дараах асуудлаар хэлэлцэн тохиролцов.

Монгол Улсын ажлын хэсгийг Монголын тал, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны ажлын хэсгийг Хятадын тал, хоёр талын ажлын хэсгийг хамтад нь талууд гэж нэрлэнэ.

1 дүгээр зүйл
Төлөвлөлт болон бүтээн байгуулалт

1. Шинээр байгуулах Цагаандэл уул-Өлзий боомтын хилээр нэвтрэх цэг нь Монгол, Хятад хоёр улсын хилийн 634 дугаар баганаас баруун тийш 1042 метр орчимд, ачаа тээврийн нийт 12 эгнээ орох гарах гарцтай төлөвлөнө. Шалган нэвтрүүлэх барилга байгууламжийг хоёр улсын хилийн шугамаас тус бүр 51 метрт байгуулж, авто замаар холбогдсон байхаар төлөвлөнө. Талуудын боомтын шалган нэвтрүүлэх барилга байгууламж болон ачаа тээврийн гарцыг ижил түвшинд барьж байгуулна. (Хавсралт зургаас харна уу)

2. Талууд шинээр байгуулах боомтын шалган нэвтрүүлэх барилга байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалтийн (шалган нэвтрүүлэх барилга байгууламж, ачаа тээврийн орц болон гарц, хилийн хяналтын ажилчдын

ажиллах болон амьдрах барилга байгууламж) ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн төлөвлөгөө, ажлын зураг, техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчны үнэлгээ зэргийг талууд өөрийн хүсэл, тогтоомжийн хүрээнд боловсруулж батлуулна.

3. Шинээр байгуулах Цагаандэл уул боомтын бүтээн байгуулалтын хугацаанд шаардлагатай барилга байгууламжийн ажлын цахилгаан хангамж болон усны эх үүсвэрийг хятадын талаас хангаж, төлбөрийг нь боомтын бүтээн байгуулалтын тослийг хоровжүүлж буй байгууллага хариуцна.

4. Шинээр байгуулах Цагаандэл уул боомтын цахилгаан эх үүсвэрийг Монголын тал өөрөө шийдвэрлэх хүртэл Хятадын талаас хангах бөгөөд төлбөрийг Монголын тал хариуцна. Монголын талын ахуйн хэрэглээний усны асуудлыг өөрөө шийдвэрлэнэ.

5. Талууд шинээр байгуулах боомтын ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөө, зураг төслийг боловсруулахдаа зорчигч болон ачаа тээврийн хяналт шалгатын үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор орчин үеийн дэвшилтэд техник, технологийг ашиглахаар төлөвлөнө.

2 дугаар зүйл

Буцалтгүй тусламжийн санхүүжилт

6. Шинээр байгуулах Цагаандэл уул боомтын шалган нэвтрүүлэх барилга байгууламж, дэд бүтцийн төлөвлөлт, зураг төсөл болон бүтээн байгуулалт (шалган нэвтрүүлэх барилга байгууламж, ачаа тээврийн орц болон гарц, хилийн хяналтын ажилтдын ажиллах болон амьдрах барилга байгууламж, байгаль орчны үнэлгээ, техник эдийн засгийн үндэслэл, ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, зураг төсөл)-н хөрөнгө оруулалтыг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн захиргааны буцалтгүй тусламжаар хэрэгжүүлнэ. Хөрөнгө оруулалтын нийт хэмжээг 114.6 (нэг зуун арван дөрвөн сая зургаан зуун мянган юань) сая юань (гаалийн татвар багтсан) дотор байхаар тогтоож, буцалтгүй тусламжийн хөрөнгийг зөвхөн дээр дурдсан зүйлд зарцуулна. Монголын тал буцалтгүй тусламжийн төслийн хөрөнгө оруулалтын хэмжээг хатуу баримталж, төслийн бүтээн байгуулалтын зардал нь буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтын нийт хэмжээнээс хэтрэхгүй байх, хэрэв давагдашгүй хүчин зүйл болон бусад шалтгаанаас болж нэмэлт зардал гарсан тохиолдолд Монголын тал өөрөө шийдвэрлэнэ.

3 дугаар зүйл

Буцалтгүй тусламжийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж

7. Хятадын талаас шинээр байгуулах Цагаандэл уул боомтын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, Монголын талд мэдээлнэ. Монголын тал хууль, тогтоомжийн хүрээнд Хятадын талын (Альшаа аймгийн захиргаа) сонгон шалгаруулсан бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана. Монголын талаас боомтын бүтээн байгуулалтад хяналт тавих байгууллагыг тогтоож Хятадын талд мэдээлэх бөгөөд боомтын зураг төслийг хүлээн зөвшөөрөх болон барилга байгууламжийг хүлээн авах стандарт нь Монголын талын холбогдох хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

4 дүгээр зүйл

Удирдлага

8. Талуудын хамтарсан ажлын хэсэг шинээр байгуулах Цагаандэл уул боомтын шалган нэвтрүүлэх барилга байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлэн ажиллаж, бүх талаар удирдана.

9. Талууд шинээр байгуулах боомтын барилга байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажил хангах, хяналт тавих байгууллагаар Хятадын талаас БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн захиргаа, Монгол талаас "Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц" төсөл хэрэгжүүлэх нэгж тус тус хариуцна.

5 дугаар зүйл

Буцалтгүй тусламжийн бодлого

10. Талуудын ажлын хэсэг болон бүтээн байгуулалтын бэлтгэл ажил хангах, хяналт тавих байгууллага нь боомтын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийг хууль, тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж, төслийн төлөвлөлт, зураг төсөл, газрын зөвшөөрөл зэрэг бэлтгэл ажилд идэвхтэй дэмжлэг үзүүлнэ. Бүтээн байгуулалтын ажлыг 2019 онд багтаан эхлүүлж, бүтээн байгуулалтын хугацаа барилга байгууламжийн ажил эхэлснээс хойш нэг жил байна.

11. Монголын тал шинээр байгуулах Цагаандэл уул боомтын шалган нэвтрүүлэх барилга байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын буцалтгүй

тусламжийн хүрээнд хийж гүйцэтгэх төсөлтэй холбоотой талуудын асуудлыг Монгол Улсын хууль, тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

6 дугаар зүйл

Ажлын талбайн зохион байгуулалт

12. Талууд шинээр байгуулах боомтын бүтээн байгуулалт болон хяналт тавих асуудалд тус тусын улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөх бөгөөд төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж нь улсын хилийн дэглэм, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал, байгаль орчин, иргэд, мал аж ахуйд сөргөөр нөлөөлөхүйц үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

13. Боомтын бүтээн байгуулалтад шаардлагатай тоног төхөөрөмж, материал, түүхий эдийг хилээр нэвтрүүлэхтэй холбоотой асуудлыг талууд хоёр улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу дипломат шугамаар шийдвэрлэнэ.

14. Боомтын бүтээн байгуулалтын талбайд нэвтрэх ажилчид, тоног төхөөрөмж, материал, түүхий эд, тээврийн хэрэгслийн төрөл, тоо хэмжээг урьдчилан хилийн шалган нэвтрүүлэх байгууллагад мэдээлж бүртгүүлэх ажлыг дуусгаснаар хилээр нэвтэрнэ.

15. Боомтын бүтээн байгуулалтын талбай дахь ажилчдын аюулгүй байдал болон бүтээн байгуулалттай холбоотой тоног төхөөрөмж, материал, түүхий эдийн бүрэн бүтэн байдлыг талууд өөрсдөө хариуцна.

16. Талууд боомтын бүтээн байгуулалтын явцад гарах маргааныг эв зүйгээр хэлэлцэж шийдвэрлэнэ.

7 дугаар зүйл

Боомтыг нээж ажиллуулах

17. Шинээр байгуулах Цагаандэл уул-Өлзий боомтын шалган нэвтрүүлэх барилга байгууламж, дэд бүтцийг барьж, хилийн хяналтын байгууллагын ажиллах нөхцөлийг бүрдүүлсний дараа дипломат шугамаар харилцан тохиролцсоноор нээж ажиллуулна.

8 дугаар зүйл

Бусад зүйл

18. Шинээр байгуулах Цагаандэл уул боомтын талбайд харагдахуйц байрлалд "Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах

Орны Альянс аймгийн туслахжаар барьж байгуулав" гэсэн үгэг бүхий жижиг дурсгалын самбар байгуулна.

19. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурсан одрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, шинээр байгуулах Цагаандэл уул-Өлзий боомтыг дипломат шугамаар харилцан тохиролцож ашиглуулснаар дуусгавар болно.

20. Түр гэрээнд тусгагдаагүй бусад асуудлын хамтарсан ажлын хэсэг харилцан тохиролцож, нэгдмэл ойлголтод хүрснээр энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг байна.

21. Энэхүү гэрээг 2019 оны 6 дугаар сарын 25-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурав. Энэхүү гэрээг Монгол, Хятад хоёр хэлээр тус бүр 4 эх хувь үйлдсэн бөгөөд хувь бүр адил хүчинтэй байна.

МОНГОЛЫН ТАЛЫН АЖЛЫН ХЭСГИЙГ ТӨЛӨӨЛЖ	**БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН АЖЛЫН ХЭСГИЙГ ТӨЛӨӨЛЖ**
Б.АСРАЛТ	**СЭ ЦЭН**
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА	**БООМТЫН АЛБАНЫ ДАРГА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР
16050 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо,
Чингүнжавын гудамж, Утас/Факс: (976-51) 26 55 78,
И-мэйл: contact@mwa.mn

2022.06.20 № 01/728

танай _____-ны №_____-т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙД Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Хүсэлт уламжлах тухай

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд, Ерөнхий Сайдын 2022 оны 01 дүгээр албан даалгавар гарсан, уг даалгаврын 7.2-д "Хилийн боомтуудын ус хангамжийн найдвартай байдлыг хангах, усны хайгуулын ажлыг гүйцэтгэх, шинэ эх үүсвэрээр хангах асуудлыг судалж танилцуулах" үүрэг өгөгдсөн.

Гашуунсухайт хилийн боомтын Барилга угсралтын ажил эхэлсэнтэй холбогдуулан 2022 онд тус боомтын ус хангамжийн асуудлыг шийдвэрлэхээр "Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төслийн нэгжтэй хамтран Гашуунсухайт, Цагаандэл-Уул хилийн боомтуудын ус хангамжийн өнөөгийн байдалтай танилцаж, газрын доорх усны хайгуул, судалгаа хийх талбайг урьдчилсан байдлаар сонгоод байна.

Иймд Гашуунсухайт, Цагаандэл-Уул хилийн боомтуудын газрын доорх усны хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай төсвийн асуудлыг шийдвэрлэх талаар Сангийн сайдад уламжилж, 2023 оны төсөвт суулгах арга хэмжээг зохион байгуулж өгнө үү.

Хавсралт ..11.. хуудастай.

Хувийг Сангийн яам, "Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төсөлд.

ДАРГА Ш.МЯГМАР

18220570

Усны газрын 2022 оны 06 дугаар
сарын 22-ны өдрийн 01/278 тоот
албан бичгийн хавсралт

Гашуунсухайт, Цагаандэл-Уул хилийн боомтын
хүн амын ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх, газрын доорх
усны хайгуул судалгааны талбайг сонгосон тухай тайлбар

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр "Албан даалгавар" -ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасан "Ногоон хөгжлийн сэргэлтийн ерөнхий төлөвлөгөөний Замын-Үүд, Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги, Булган, Бичигт, Цагаандэл-Уул боомтын болон хөгжлийн төслүүдийн усан хангамжийн найдвартай байдлыг хангах, усны хайгуулын ажлыг гүйцэтгэх, шинэ эх үүсвэрээр хангах асуудлыг судалж танилцуулах, шаардлагатай арга хэмжээ авах ажилд мэргэжил арга зүйгээр ханган ажиллах" ажлын хэсгийг Усны газрын даргын 2022 оны А/08 тоот тушаалаар байгуулан ажиллаж байна. Тус ажлын хэсэг нь Сангийн яамны дэргэдэх "Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төслийн нэгжтэй хамтран Гашуунсухайт, Цагаандэл-Уул хилийн боомтуудын ус хангамжийн өнөөгийн байдалтай танилцаж, ус хангамжийн зориулалттай газрын доорх усны хайгуул, судалгаа хийх талбай сонгох ажлыг 2022 оны 05 дугаар сарын 14-20-ны өдрүүдэд гүйцэтгэсэн.

Ажлын хэсгээс Гашуунсухайт, Цагаандэл-Уул хилийн боомтын хүн амын ус хангамжийн зориулалттай газрын доорх усны эх үүсвэрийн хайгуул судалгаа хийх боломжтой дараах талбайг сонгоод байна. Үүнд:

Талбайн нэр	Судалгааны талбайн солбицол	Хайгуул, судалгааны ажлаар гүйцэтгэх ажил	Хайгуул, судалгааны ажилд зарцуулагдах төсөв
1. Гашуунсухайт хилийн боомт			
Талбай-1. Жаргалантын хөндий	42°26'07", 107°40'24"; 42°25'10", 107°37'25"; 42°30'59", 107°33'59"; 42°31'55", 107°36'52"	Талбайн геофизикийн судалгаа – 51.5км^2 талбай 1, 93.4 км^2 талбай 2; Гидрогеологийн эрлийн цооног өрөмдлөг – 800т/метр; Гидрогеологийн хайгуул-ашиглалтын цооног өрөмдлөг – 500т/метр; Гидрогеологийн шавхалт, туршилтын ажил – 576 цаг	900,000,000 (есөн зуун сая) төгрөг
Талбай-2. Галбын говийн талбай	42°36'11", 107°19'53"; 42°37'56", 107°15'08"; 42°44'26", 107°19'02"; 42°42'50", 107°23'35"		
2. Цагаандэл-Уул хилийн боомт			
Мухар тагийн амны талбай	41°51'15", 104°19'53"; 41°50'17", 104°16'52"; 41°51'24", 104°16'17"; 41°50'45", 104°17'58"	Талбайн геофизикийн судалгаа – 10.1км^2 талбайд; Гидрогеологийн эрлийн цооног өрөмдлөг – 500т/метр; Гидрогеологийн хайгуул-ашиглалтын цооног өрөмдлөг – 400т/метр; Гидрогеологийн шавхалт, туршилтын ажил – 360 цаг	700,000,000 (долоон зуун сая) төгрөг

Тус боомтуудын ус хэрэглээнд шаардлагатай газрын доорх усны эх үүсвэрийн хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэх, ус ашиглалтад бэлтгэх, шугам сүлжээ татахаас өмнө хийх нэн тулгамдсан асуудал болоод байна.

Иймд газрын доорх усны хайгуулын үе шатны ажил хийж, хайгуул-ашиглалтын цооног өрөмдөн технологийн дагуу тоноглож, ашиглалтад бэлтгэх, газрын доорх усны ордын нөөцийг нэмэгдүүлэн батлуулж боомтын ус хэрэглээг хангах, мөн түүнчлэн усыг цэнгэгшүүлэх тоног төхөөрөмжийг суурилуулан унд ахуйн стандартад тохирох усыг хэрэглэгчид хүргэх шаардлагатай байна.

Усны газар

ӨМНӨГОВЬ АЙМАГТ АЛБАН ТОМИЛОЛТООР АЖИЛЛАСАН АЖЛЫН ХЭСГИЙН ИЛТГЭХ ХУУДАС

2022.05.23

Нэг. Ажлын хэсгийн зорилго

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр "Албан даалгавар" -ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасан "*Ногоон хөгжлийн сэргэлтийн ерөнхий төлөвлөгөөний Замын-Үүд, Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги, Булган, Бичигт, Цагаандэл-Уул боомтын болон хөгжлийн төслүүдийн усан хангамжийн найдвартай байдлыг хангах, усны хайгуулын ажлыг гүйцэтгэх, шинэ эх үүсвэрээр хангах асуудлыг судалж танилцуулах, шаардлагатай арга хэмжээ авах ажилд мэргэжил арга зүйгээр ханган ажиллах*" ажлын хүрээнд, Сангийн яамны дэргэдэх "Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төслийн нэгжийн хүсэлтээр тус төслийн нэгжтэй хамтран Гашуунсухайт боомтод өмнө нь ашиглаж байгаад ажиллагаагүй болсон дөрвөн худгийг шалгах, ус хангамжийн зориулалттай усны хайгуул судалгаа хийх нэн шаардлагатай байгаа Гашуунсухайт, Цагаандэл-Уул хилийн боомтуудын ус хангамжийн зориулалттай газрын доорх усны хайгуул, судалгаа хийх талбайг сонгох, тайлан бичиж шийдвэрийн төсөл боловсруулах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Мөн түүнчлэн тухайн боомтуудын усны хайгуул судалгааны ажлын төсвийг шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг шийдвэрийн төсөлтэй хамт холбогдох нэгжид хүргэхэд оршино.

Хоёр. Томилолтоор ажилласан аймаг, сум, хугацаа

Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутаг дахь Цагаандэл-Уул боомт, Ханбогд сумын нутаг дахь Гашуун сухайт боомтод 2022 оны 05 дүгээр сарын 14-20-ний өдрүүдэд ажиллалаа.

Гурав. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийг Усны газрын Усны нөөцийн хэлтсийн дарга Я.Болдбаатар ахалж, ажлын хэсэгт Усны газрын Усны нөөцийн хэлтсийн усны хайгуул судалгаа хариуцсан мэргэжилтэн Б.Мөнгөнтуул, Геологи-минерологийн ухааны доктор, Монгол улсын зөвлөх инженер, гидрогеологич З.Цэрэндорж, Монгол улсын зөвлөх инженер, гидрогеологич Н.Мөнхбаатар (Усны газрын даргын 2022 оны А/08 дугаар тушаалаар баталсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн дэх) Алтайн өвөр говийн сав газрын захиргааны мэргэжилтэн Н.Түмэнжаргал, "Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төслийн архитектур төлөвлөлт, судалгааны албаны дарга Б.Мягмаржав, Газар зохион байгуулагч Г.Баасанжав нар ажиллалаа.

Дөрөв. Томилолтын хүрээнд хийгдсэн ажлууд:

1. Гашуунсухайт хилийн боомтын орчимд гаргасан хоёр худгийг цооногийн дурангаар харж шалгасан ба насос суурилуулан ашиглаж байгаа хоёр худгийг үзэж, ашиглалтын явцын мэдээллийг цуглуулсан /Хүснэгт1, Зураг 1-8/;
2. Гашуунсухайт хүртэлх төмөр замын трассын дагуу 2021 оноос хойш шинээр гаргасан худгуудыг үзэж, мэдээлэл авсан;
3. Цагаандэл-Уул хилийн боомтын орчимд Мухар тагийн ам нэртэй газар "Дунар-Од" ХХК-ийн 2016 онд гаргасан МТ-7, МТ-9 цооногуудын усны түвшин, цооногийн гүнийг хэмжиж, усны сорьц авч лабораторийн шинжилгээнд хамруулласан /Хүснэгт2, Зураг 9-12/.

4. Гашуунсухайт, Цагаандэл-Уул хилийн боомтуудын газрын доорх усны хайгуулын судалгаа хийх талбайг газар дээр нь үзэн, талбай сонгож, мэдээлэл цуглуулсан.

Тав. Дүгнэлт

1. Гашуунсухайт хилийн боомт: Хилийн цэрэг, гааль зэрэг байгууллагын унд ахуйн хэрэглээнд шаардлагатай усны эх үүсвэрийг хамгийн ойр олох зорилгоор олон тооны гүний худгийг боомт орчимд гаргаж байсан бөгөөд тэдгээр худгуудыг бүртгэж, паспорт хөтлөөгүй байна. Дээрх худгуудад тодорхой хариуцагч эзэн байхгүйн улмаас ашиглалтын үеийн зөв горимыг мөрдсөн эсэх, эвдрэл гэмтэл юунаас үүссэн нь тодорхойгүй байна. Худгуудад хэмжилт хийж, дурандсан үр дүн, талбай дээр ажиллах үед авсан мэдээлэл /аман асуулга/ -ээс авч үзэхэд худгийн насосны хүчин чадал, насос суурилуулах гүн, ус өргөх хоолойг оновчтой сонгоогүй, ус өргөх хоолой нь чанарын шаардлага хангаагүй байна. Тодруулбал хагарч гэмтсэн ус өргөх хоолой ашиглах үед худаг уруугаа ус алдагдах, усны даралт бага буюу авч буй усны хэмжээ бага байх, их хугацаа зарцуулах болдог. Үүнээс гадна боомтын орчимд урьд өмнө газрын доорх усны хайгуул судалгааны ажил хийгдэж байгаагүй тул тус талбайн усжилтийн байдал, газрын доорх усны нөөцийг шууд тодорхойлох боломжгүй юм.

Харин Галбын говийн газрын доорх усны орд нь боомтоос хамгийн ойр зайд газрын доорх усны эрэл-хайгуулын судалгаа хийж, нөөцийг баталгаажуулсан орд бөгөөд 2.5 г/л эрдэсжилттэй ус байна. Хайгуулын ажлыг "Оюутолгой" ХХК-ийн хөрөнгө оруулалтаар 2003-2004 онд хийсэн ба тэр үед гаргасан 15л/сек ундаргатай GG-1 цооног нь боомтоос 32км-ийн зайд байрлана. Томилолтын хүрээнд Гашуунсухайт орчмын худгуудад хийсэн хэмжилт, судалгааны үр дүнг хүснэгт 1-д тодорхой үзүүлэв.

Ус хэрэглээ нь боомтод 13.6м^3/хон, суурьшлын бүсэд 23м^3/хон буюу нийт 36.6 м^3/хон байна /эх сурвалж: "Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төслийн нэгж, зураг төсөл зохиогч/. Иймд цаашид өсөн нэмэгдэх боомтын ус хэрэглээнд шаардлагатай газрын доорх усны эх үүсвэрийн хайгуул судалгааны ажил хийх нь ус ашиглалтад бэлтгэх, шугам сүлжээ татахаас өмнө хийж гүйцэтгэх нэн тулгамдсан асуудал болоод байна.

2. Цагаандэл-Уул хилийн боомт: "Өлзийт Альшаа" ХХК-ийн хөрөнгө оруулалтаар "Дунар-Од" ХХК нь "Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутаг дахь Цагаандэл-Уул, Номгон сумын нутаг дахь Онч хайрхан уулын хэсэг, Мухар тагийн амны хэсэгт 2016 онд газрын доорх усны эрэл, эрэл-хайгуулын ажил"-ыг гүйцэтгэсэн байна. Тус судалгааны ажлаар боомтоос зүүн хойш 4.5 км-т орших боржин чулуулгийн ан цав, хагарлын бүсэд гаргасан МТ-7, МТ-9 цооногуудын нийлбэр нөөцийг 2.1л/сек-ээр тооцож, боломжит нөөцийг батлуулсан. Мөн МТ-5 цооногт 2л/сек-ээр сорилын шавхалт хийсэн ба усны найрлага нь эрдэсжилт өндөртэй, рашаан төст шинж чанартай байсан тул цооногийг хааж, энэ цооногийн усны нөөцийг тооцоогүй байна. Ажлын хэсэг нь дээрх цооногуудын усны түвшин, цооногийн гүнийг хэмжиж, усны сорьц авсан /хүснэгт 2/.

Боомтын барилга, угсралтын ажил нь 2022 онд эхэлсэн ба энэ үе шатанд хэрэглэх усыг шийдвэрлэх, мөн түүнчлэн цаашид өсөн нэмэгдэх боомтын ус хэрэглээнд шаардлагатай газрын доорх усны эх үүсвэрийн нөөцийг нэмэгдүүлэх хайгуул судалгааны ажил хийх нь ус ашиглалтад бэлтгэх, шугам сүлжээ татахаас өмнө хийж гүйцэтгэх нэн тулгамдсан асуудал болоод байна.

Зургаа. Цаашид авах арга хэмжээний санал:

Гашуунсухайт боомтын хүрээнд:

1. Нэн тэргүүнд шаардлагатай байгаа боомтын барилга, угсралтын ажилд хэрэглэх усыг хангахын тулд боомт орчмын худгийн ус өргөх хоолойг шинэчлэн, худгийн ундаргад тохирсон хүчин чадалтай насос суурилуулах, цооногуудад засвар үйлчилгээ хийх ажлыг усны мэргэжлийн байгууллагаар (туршлагатай) хийлгэж ус ашиглах;
2. Одоо ашиглаж байгаа худгуудыг эзэн, харьяалалтай болгох, худгуудыг паспортжуулж, бүртгэлжүүлэх, ашиглалтаас гарсан худгуудыг битүүмжлэн актлах шаардлагатай;
3. Цаашид өсөн нэмэгдэх боомтын ус хэрэглээг хангах зориулалтаар газрын доорх усны эх үүсвэрийн хайгуул судалгаа хийж гүйцэтгэх шаардлагатай ба хайгуул хийх боломжтой дараах хоёр талбайг сонгож байна.

   - *Талбай-1*. Гашуунсухайт боомтын зүүн талаар орших Жаргалантын хөндий (зүүн урдаас баруун хойш чиглэлтэй сунаж тогтсон) нь газрын доорх усны хайгуул судалгаа хийх боломжтой хамгийн ойр (5-10км) талбай байна. Иймд тус хөндийд геофизикийн судалгааны ажил гүйцэтгэж, гидрогеологийн эрлийн судалгаа хийх, боломжит усны эх үүсвэр олсон тохиолдолд судалгааг үргэлжлүүлэн хийж, нөөцийг баталгаажуулах (Зураг 13). Мөн усыг цэнгэгшүүлэх тоног төхөөрөмжийг суурилуулан унд ахуйн стандартад тохирох усыг хэрэглэгчид хүргэх шаардлагатай;
   - *Талбай-2*. Дээрх талбайд газрын доорх усны эх үүсвэр тогтоогоогүй тохиолдолд Галбын говийн газрын доорх усны ордын талбайд газрын доорх усны эрэл-хайгуулын дараагийн шатны судалгааг хийж, ашиглалтын худаг өрөмдөн, технологийн дагуу тоноглож боомтын усны нөөцийг батлуулан ус хэрэглээг хангах нь зүйтэй (Зураг 13).

Цагаандэл-Уул боомтын хүрээнд:

1. Боомтын барилга, угсралтын ажилд хэрэглэх усыг хангахын тулд 2016 онд хийгдсэн гидрогеологийн эрэл-хайгуулын судалгааны ажлын үед гаргасан МТ-7 болон МТ-9 цооногуудад 1.1 – 1.3 *л/с* хүчин чадалтай гүний худгийн насос суурилуулж, тэдгээрээс ус авч ашиглах (*Жич: Эдгээр цооногууд нь боомтоос зүүн хойш 4.5 км-т байрладаг ба шүүрийн яндангийн голч нь 100 мм байгаа болохоор түүн дотор багтах насос суурилуулж, хайгуулын судалгааны үед тогтоосон ундаргад нь тохирсон хэмжээний ус авч ашиглах нь тохиромжтой болно*);
2. Цаашид өсөн нэмэгдэх боомтын ус хэрэглээг хангахын тулд газрын доорх усны эх үүсвэрийн эрэл-хайгуулын судалгаа хийсэн Мухар тагийн амны талбайд нэмэлт хайгуулын ажил хийж, газрын доорх усны нөөцийг нэмэгдүүлэх, баталгаажуулах шаардлагатай байна (Зураг 14). Энэ үе шатны судалгаагаар ашиглалтын худаг өрөмдөж технологийн дагуу тоноглон боомтын цаашид өсөн нэмэгдэх усны хэрэглээг хангах нь зүйтэй. Мөн усыг цэнгэгшүүлэх тоног төхөөрөмжийг суурилуулан унд ахуйн стандартад тохирох усыг хэрэглэгчид хүргэх шаардлагатай;


ТАНИЛЦСАН:
УСНЫ ГАЗРЫН ДАРГА Ш.МЯГМАР

ХЯНАСАН:
Усны нөөцийн хэлтсийн дарга Я.БОЛДБААТАР


ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
Усны нөөцийн хэлтсийн
Усны хайгуул судалгаа хариуцсан
мэргэжилтэн Б.МӨНГӨНТУУЛ

Хүснэгт1. Гашуунсухайт хилийн боомт орчимд гаргасан худгийн мэдээлэл.

Цооногийн дугаар	Байршил	Кординат	Цооногийн гүн, м	Суултын яндан/ шүүрийн цувааны голч, мм	Усны тогтсон түвшин /ц.а-аас/, м	Ундарга, л/сек	Тайлбар
Худаг 1 /цооногийн дуран/	Гашуунсухайт хилийн боомт орчим	42 24 51.05" 107 34 11.95"	198	100	32.1	-	Цооногт дуран хийж үзэхэд 178м-т багаж тулсан. Суултын яндангийн хана шаварлаг материал наалдсан байсан ба шүүр /ган/ суулгасан гүн тодорхой харагдаагүй. Харин 152м-ээс эхлэн дуранд харагдах енгө нь цайрч, суултын яндангийн хана илүү тунгалаг болж, цуулбар шүүр харагдаж эхэлсэн. Иймд 152м-ээс нэг уст давхаргын үе эхэлж байна гэж таамаглалаа. Уг худгийн яг хажууд гаргасан худгаас анх 7.5м³/цаг -аар ус авч ашиглаж байсан гэх ба явцдаа 4.5м³/цаг болж, одоогийн байдлаар 1.5 м³/цаг болсон байна.
Худаг 2 /цооногийн дуран/	Гашуунсухайт хилийн боомт орчим	42 25 02.7" 107 34 02.12"	-	159	18.1	-	Цооногт дуран хийж үзэхэд 28.3-37 м-т нүхэлсэн ган шүүр суулгасан байсан ба 42.7м-т суултын яндан тасарч хазайсан /яндан хоорондын хазайлтаар хоосон орон зай үүссэн нь 10см орчим/ байв. Тасарсан яндан хазайсан учир дурангийн үзүүр ханаа дагаж яваад хоосон орон зайруу орох гээд, доош харах ямар ч боломжгүй болсон.
Худаг 3 /насостай/	Гашуунсухайт хилийн боомт орчим	42 26 12.76" 107 33 16.87"	-	100	-	-	Насос суулгасан, 32мм-ийн голчтой ус өргөх хоолойгоор ус авдаг. 7тн усыг 4 цагт авдаг ба ус өргөх хоолой зарим хэсэгтээ цуурч эвдэрсэн тул гарч байгаа усны хэмжээ даралтгүй, усаа эргэж алддаг гэж мэдээлсэн.
Худаг 4 /насос унагасан/	Гашуунсухайт хилийн боомт орчим	42 25 28.83" 107 35 38.19"	-	100	-	2.5 /аман асуулга/	Худагт насос унагасан байсан ба 2.5л/сек ундаргаар ус авч ашиглаж байсан гэж өмнөх хэрэглэгчид мэдээлсэн.
Худаг 5 /насостай/	Хайрхан баг	42 30 07.66" 107 31 36.51"	-	100	-	-	Хүрмэн сумын Хайрхан багын ус хэрэглээнд насос суулгасан /50мм-ийн ус өргөх хоолойтой/. Худгийн бүтээмж анх хэрэглэж байсан үеэс буурсан байгаа гэж мэдээлсэн.
Худаг 6 /GG-1 цооног/	Галбын говын газрын доорх усны орд	42 38 44.16" 107 19 58.79"	-	-	-	15.0	Галбын говийн газрын доорх усны ордын эрэл-хайгуулын ажлаар гаргасан цооног ба орон нутагт хүлээлгэн өгсөн байна. Гашуунсухайт хилийн боомтоос 32км-ийн зайд байрлана. Эрдэсжилт 2.5г/л.




Зураг 1. Худаг 1-т дурангаар харж буй.




Зураг 2. Худаг 2-т дурангаар харж буй.




Зураг 3. Худаг 2-т дурангаар харж буй.



Зураг 4. Худаг 2-ийн суултын яндан тасарч хазайсан хоосон орон зай.




Зураг 5. Худаг 3-т 32мм-ийн ус өргөх PVC хоолойгоор тоноглосон ба цуурч эвдэрсэн.



Зураг 6. Худаг 4-т насос унагасан, ашиглах боломжгүй байгаа.



Зураг 7. Худаг 5 буюу Хайрхан багийн худаг, худгийн ашиглалтын ундарга багассан.



Зураг 8. Худаг 6 (GG-1 цооног) Галбын говийн газрын доорх усны эрэл хайгуулын судалгаагаар 15л/сек-ээр шавхалт хийсэн гидрогеологийн эрлийн цооног.

Хүснэгт2. Цагаандэл-Уул хилийн боомт орчимд гаргасан цооногийн мэдээлэл.

Цооногийн дугаар	Байршил	Кординат	Цооногийн гүн, м /еремд-легеер/	Суултын яндан/ шүүрийн цувааны голч, мм	Усны тогтсон түвшин /ц.а-аас/, м	Ундарга, л/сек	Тайлбар
МТ-7	Мухар таг	41 52 01.18" 104 18 38.89"	150	100 PVC	2.40	1.3	Цооногийн гүнийг хэмжихэд 145м-т байв. Усны химийн дэлгэрэнгүй болон бичил элементийг тодорхойлох /шинжилгээнд өгөх/ зорилгоор цооногоос 1.5литр сорьц авсан.
МТ-9	Мухар таг	41 52 07.60" 104 18 49.30"	150	100 PVC	0.53	1.1	Усны химийн дэлгэрэнгүй болон бичил элементийг тодорхойлох /шинжилгээнд өгөх/ зорилгоор цооногоос 1.5литр сорьц авсан.
МТ-5	Мухар таг	41 51 11.94" 104 18 04.56"	150	Тоноглоогүй, хаасан	-	2.0	Усны найрлага нь эрдэсжилт ендертэй, рашаан тест шинж чанартай байсан тул цооногийг хааж, тоноглоогүй ба неец тооцоогүй байна.



Зураг 9. МТ-7 цооног хэмжилт хийж буй.




Зураг 10. МТ-9 цооног хэмжилт хийж буй.



Зураг 11. МТ-7, МТ-9 цооногуудаас усны сорьц авсан.



Зураг 12. МТ-5 цооног.



Зураг 14. Цагаандэл-Уул хилийн боомтын ус хангамжийн зориулалттай газрын доорх усны эрэл хайгуулын судалгаа хийх талбайн зураг.

БАТЛАВ. ЭРЧИМ ХҮЧНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА Б.НАСАНТОГТОХ

Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутаг дахь "Цагаандэл-Уул" хилийн автозамын боотмын барилга байгууламжийн цахилгаан хангамжийн

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛИЙН СУНГАЛТ

Олгосон огноо. 2024.06.11 № 01/8092/ЭЗГ Улаанбаатар хот

1. Техникийн нөхцөл хүссэн иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг	***"ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ-ДЭД БҮТЭЦ" ТӨСӨЛ*** *Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Ж.Самбуугийн гудамж, М-плаза, 14 давхар, 1401 тоот,*
2. Техникийн нөхцөл хүссэн байршил	*Өмнөговь аймаг, Хүрмэн сум*
3. Ажил үйлчилгээний зориулалт	*"Цагаандэл-Уул" хилийн автозамын боотмын барилга байгууламжийн цахилгаан хангамж,*
4. Техникийн нөхцөл олгох, сунгах үндэслэл	*- Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 5/1456 тоот албан бичиг,* *- Эрчим хүчний сайдын 2021 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн а/1402 тоот албан бичиг,* *- "Анукатод" ХХК-ийн боловсруулан батлуулсан, ажлын зураг,* *- "Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төслийн 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 05 тоот албан бичиг,* *- Эрчим хүчний сайдын 2022 оны А/96 дугаар тушаалаар байгуулагдсан "Цахилгааны техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх ажлын хэсэг"-ийн 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн хурлын шийдвэрийн товч тэмдэглэл,*
5. Суурилагдсан чадал	*2463 кВА*
6. Тоолуур, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлага	*6.1 Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орж, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх.* *6.2 RS-485-ийн гаралтын интерфэйстэй олон улсын IEC61107, IEC62056 холболтын стандартуудын шаардлага хангасан байх.*

	6.3 Санах ой бүхий 0.2 нарийвчлалтай бүрэн электрон тоолуур суурилуулах. 6.4 Шинээр суурилуулж буй тоолуурууд нь тоолуурын нэгдсэн системд холбох. Мэдээлэл дамжуулах боломжийг бүрдүүлсэн байх. 6.5 Тоолуур, хянах, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлагыг хангагч байгууллага "ӨБЦТС" ТӨХК-аас авах. Ажлын зураг төсөл боловсруулах шатанд суурилуулах тоолуурын төрөл, марк, схемийг тухайн байгууллагаар хянуулсан байх.
7. Гүйдлийн трансформаторт тавигдах шаардлага	7.1 Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орон, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх. 7.2 Холбогдох тооцооны дагуу ачаалал хэрэглээнд тохирсон коэффициент бүхий гүйдлийн трансформатор суурилуулах. 7.3 Олон улсын IEC 61869-2 стандартын шаардлагыг хангасан, реле хамгаалалт, хэмжүүр, хянах хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлагуудыг бүрэн хангасан, 0.2 нарийвчлалтай гүйдлийн трансформатор суурилуулах.
8. Холбогдох цэг	8.1 Цагаандэл-Уул хилийн боомт орчмын хилийн цэгээс БНХАУ-ын импортын 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамнаас салбарлуулан, шинээр 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 10/0.4 кВ-ын 2х800 кВА хүчин чадалтай дэд станц /ХТП маягийн/, 10/0.4 кВ-ын 63 кВА хүчин чадалтай дэд станц /АТП маягийн/-ууд барьж, боомтын барилга байгууламжийг цахилгаан эрчим хүчээр хангах.
9. Дамжуулах, түгээх сүлжээний шугам, дэд станцыг өргөтгөх шаардлага	9.1 Шинээр баригдах 10 кВ-ын цахилгаан дамжуулах шугам нь MNS 6522:2015 стандартуудын шаардлагыг хангасан байх. 9.2 Шинээр татах 10 кВ-ын шугамын хөндлөн огтлолыг хэрэглээ ачаалалтай уялдуулан зураг төслийн шатанд тооцоогоор тодорхойлон, ашиглагч байгууллага "ӨБЦТС" ТӨХК-тай зөвшилцөн сонгох. 9.3 Дэд станцын 10/0.4 кВ-ын трансформаторууд нь хүчдэл тохируулгын 5 шатлал бүхий олон улсын IEC 60076-10 стандартын шаардлагыг хангасан байх, 9.4 Дэд станцын 10 кВ, 0.4 кВ-ын оруулга, гаргалгааны шугам, тоноглолуудад олон улсын стандартын шаардлага хангасан орчин үеийн микропроцессорын хамгаалалтыг холбогдох тооцооны дагуу суурилуулах, зураг төсөл боловсруулах шатанд ашиглагч байгууллага "ӨБЦТС" ТӨХК-тай зөвшилцөх, тавцл тооцоог тус компаниар хийлгүүлэх, 9.5 Шинээр суурилуулж буй тоноглолууд нь Монгол орны цаг уурын нөхцөл, далайн түвшний өндөрлөг, IEC стандарт, техник ашиглалтын дүрмийн шаардлага хангасан байх бөгөөд өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, ±10%-ийн хүчдлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах,

	9.6 Хуваарилах байгууламж, дэд станцуудад Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 339 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-д заасны дагуу галын аюулгүй байдлыг хангах,
	9.7 Шугам, дэд станцын гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллага "ӨБЦТС" ТӨХК-д хүлээлгэн өгөх, гүйцэтгэлийн зургийг гаргахдаа кабель шугамын холболтын муфтуудыг заасан, бусад инженерийн шугам сүлжээ, авто замтай огтлолцсон хэсгийн зүсэлтийг тусгах
10. Реле хамгаалалт, автоматикийн байгууламжид тавих шаардлага	*10.1 Энэхүү техникийн нөхцлийн дагуу суурилуулах реле хамгаалалт, автоматикийн тоног төхөөрөмжүүд, удирдлага, хяналт, мэдээллийн системүүд нь "Бодлогын бичиг баримт батлах тухай" Эрчим хүчний сайдын 2019 оны 335 дугаар тушаалаар батлагдсан "Реле хамгаалалт, системийн автоматикийн талаар бариmтлах бодлогын баримт бичиг", "Эрчим хүчний салбарт бариmтлах мэдээллийн технологийн бодлогын баримт бичиг"-т заасан шаардлагуудыг бүрэн хангах, хангагч байгууллага "ӨБЦТС" ТӨХК-тай зураг төсөл боловсруулах шатанд зөвшилцсөн байх.*
	10.2 Хуваарилах байгууламж, шугам, дэд станцын оруулга, гаргалгааны тоноглолуудад олон улсын стандартын шаардлага хангасан орчин үеийн микропроцессорын хамгаалалтыг холбогдох богино залгааны тооцоонуудыг хийж, ашиглагч байгууллага "ӨБЦТС" ТӨХК-тай зөвшилцөн сонгох.
	10.3 Үндсэн, бэлтгэл хамгаалалтуудыг олон улсын IEC-61000, IEC-60258, IEC-60068, IEC-61850 зэрэг стандартын шаардлага хангасан орчин үеийн микропроцессорын хамгаалалтыг холбогдох тооцоонуудыг хийж сонгох,
	10.4 Реле хамгаалалт автоматикийн тавилын тооцоог хангагч байгууллага "ӨБЦТС" ТӨХК-аар хийлгэх.
11. Реактив чадлын зохицуулалт	-
12. Цахилгаан эрчим хүчний чанарыг хянах хэрэгсэл, чанарын үзүүлэлтийг тогтворжуулах төхөөрөмжийн хэрэгцээ	-
13. Нэг мөгийн зураг төсөл хэрэглэх зөвлөмж	*13.1 Зургийн дөвгөврыг эрх бүхий байгууллагаас авах.*
	13.2 Ажлын зураг төсөл боловсруулахдаа Монголын Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын 5 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллага болон ашиглагч байгууллага "ӨБЦТС" ТӨХК-тай зөвшилцсөн байх.
	13.3 Зураг төсөл боловсруулах шатанд холболт хийх цэг, ячейкны дугаар, шуурхай ажиллагааны нэр, зарчимын схем, хоёрдогч хэлхээний зургийг ашиглагч байгууллага "ӨБЦТС" ТӨХК-тай зөвшилцөх.

14. Гэнэтийн гэмтэл саатал, аваарийн үед ашиглах бэлтгэл тэжээл, бие даасан цахилгааны үүсгүүр суурилуулах шаардлага	
15. Цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүйн ажиллагааны байдал	*15.1 "Эрчим хүчний тухай" хуулийн 30.1.8 "Өөрийн эзэмшлийн шугам, сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах" гэж заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний заагт доторхи цахилгаан тоног төхөөрөмжиндөө байнгын үзлэг шалгалт хийх, хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээг хийлгэх.*
16. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа	*16.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.9-д заасны дагуу 2026 оны 06 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл /2 жилийн хугацаанд/ хүчинтэй.* *16.2 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.13-д заасны дагуу* ***техникийн нөхцөлийн дагуу зураг төслийн байгууллагаар хийлгэж, холбогдох байгууллагаар хянуулж, эрх бүхий байгууллагаар магадлал хийлгэж баталгаажуулсан байна.*** *16.3 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацааг сунгуулахдаа хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.16-д заасны дагуу баталгаажуулсан зураг төслийг ирүүлнэ.* ***Хэрэв баталгаажуулсан зураг төсөл ирүүлээгүй тохиолдолд техникийн нөхцөлийн хүчинтэй хугацааг сунгахгүй.***
17. Дагаж мөрдөх хууль, дүрэм, журам	*17.1 Дэд станц, цахилгаан дамжуулах шугамын байршлын зургийг эрх бүхий хийлгэж, нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газраар батлуулан, мэдээллийн санд оруулсан байх,* *17.2 Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад трассын дагуу дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээх зардлыг төсөвт тусгах,* *17.3 Шугам, дэд станцын зураг төсөл боловсруулах, угсралт, туршилт, тохируулгын ажлыг "Цахилгаан байгууламжийн угсралтын дүрэм" (2003 он), Эрчим хүчний тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу эрчим хүчний бүрэлгэ байгууламжийн зураг төсөл ба угсралтын ажлыг гүйцэтгэх "Тусгай зөвшөөрөл" бүхий мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэх* *17.4 "Эрчим хүчний тухай" хуулийн 29.1.9 "Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж болох эрхтэй" гэж заасны дагуу өөрийн тоногполоос хангагч байгууллагын

зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах үүрэгтэй.

18. Техникийн нөхцөлийн хүчингүйд тооцох заалт

18.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.16, 2.17-д заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно.

2.16 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд холболт хийгдээгүй тохиолдолд хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулах хүсэлтээ энэ дүрмийн 2.13-т заасан баталгаажуулсан зураг төслийн хамт техникийн нөхцөл олгосон байгууллагад ирүүлнэ.

2.17 дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:

2.17.1. хүчинтэй хугацаа дууссан;

2.17.2. техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн;

2.17.3. холбогдох цэгийн хүчин чадлаас хэтрүүлсэн;

2.17.4. дамжуулагчаас санал аваагүй, өөрийн эзэмшлийн түгээх сүлжээнд ирсэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгохдоо дамжуулах сүлжээнд холбогдох техникийн нөхцөлд заагдсан хүчин чадлаас хэтрүүлсэн.

18.2 Олгосон чадлаас хэтрүүлэн чадал ашигласан тохиолдолд

АЖЛЫН ХЭСГИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АЖЛЫН ХЭСГИЙН ОРЛОГЧ ДАРГА:

ЭРЧИМ ХҮЧНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ЦАХИЛГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА Д.БАТЗОРИГ

АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

ЭРЧИМ ХҮЧНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ЦАХИЛГААНЫ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Д.ЭНХҮҮШ

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН ТАЛААРХ ТЭМДЭГЛЭЛ:

Хүсэлт гаргасан хуулийн этгээдийг төлөөлж:

Хүлээн авч, техникийн нөхцөлийн заалтууд, тухайн техникийн нөхцөл хүчингүйд тооцох заалттай танилцсан эсэх

☑ Тийм ☐ Үгүй

Нэр: А.Ермек

Регистрийн дугаар: ЬЭ78032639

Холбоо барих: 88091103

Огноо: 2024.07.22

Гарын үсэг:

85

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mrt.gov.mn,
Цахим хуудас: www.mrt.gov.mn

2024.12.11 № 03/2151
танай 2024.12.02 -ны № хэг/2379

Асуултын хариу хүргүүлэх тухай

Монгол-Хятадын хилийн Цагаандэл Уул-Өлзий боомтын бүтээн байгуулалтын талаар Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн асуулгад Зам, тээврийн яамны эрхлэх асуудлын хүрээнд авто замтай холбоотой дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

Засгийн газрын 2018 оны 330 дугаар тогтоолын дагуу концессын гэрээг "Ундрах говь" ХХК-тай 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан ба 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр концессын гэрээ хүчин төгөлдөр болсон боловч өнгөрсөн хугацаанд авто замын трасс дагуух орон нутгийн ард иргэд, төрийн бус байгууллагууд боомт нээх, авто зам барих ажлыг эсэргүүцэж байгаагаас шалтгаалан ямар нэгэн шийдэлд хүрээгүй, зам барилгын ажил эхлүүлэх нөхцөл хангагдаагүй байна.

Харин концессын гэрээ, үнийн дүн болон гэрээний хэрэгжилттэй холбоотой мэдээллийг концессын гэрээний тал бөгөөд эрх бүхий этгээд болох Эдийн засаг, хөгжлийн яамнаас тодруулахыг хүсье.

"ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ"
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
С.БАТБОЛД
2024.12.11 13:02

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД

Засгийн газрын XI байр, Ж.Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2024. 12. 16 № 01/2747

танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Ч.УЧРАЛ ТАНАА

Танаас ирүүлсэн "Цагаандэл Уул-Өлзий" боомтын бүтээн байгуулалттай холбоотой эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуултын хариуг ирүүлэх тухай албан бичигтэй танилцлаа.

Улсын Их хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангаас ирүүлсэн асуултын 5 дугаарт холбогдох мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт:.....хуудастай.

Л.ГАНТӨМӨР

240861

Хавсралт

5. Боомт руу холбох 270 км авто замын концессын гэрээ, үнийн дүн болон ажлын гүйцэтгэлийн явц, гэрээний хэрэгжилтийн дэлгэрэнгүй мэдээлэл.

Засгийн газрын 2018 оны 330 дугаар тогтоолоор эрх олгосны дагуу Үндэсний хөгжлийн газар "Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл Уул" хилийн боомт хүртэлх 270 км авто зам төслийг хэрэгжүүлэх зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх (DBOT) концессын гэрээ"-г "Ундрах говь" ХХК-тай 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан.

Тус концессын гэрээнд төслийн нийт хөрөнгө оруулалт 258,026,000.00 ам.доллартай тэнцэх төгрөг, төслийн гэрээний хугацаа гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 25 жил 6 сар, авто замын барилга угсралтын ажлыг 2022 оны 2 дугаар улиралд багтаан эхлүүлэн 2024 оны 2 дугаар улиралд багтаан дуусгах, авто замын ашиглалтын хугацаа 20 жил байхаар заасан.

Одоогийн байдлаар концессын гэрээ хэрэгжих урьдчилсан нөхцөл хангагдаж, концессын гэрээ хүчин төгөлдөр болсон, авто замын техник, эдийн засгийн үндэслэл болон зураг төсөл хийгдэж батлагдсан боловч төслийн барилга угсралтын ажил дараах шалтгааны улмаас концессын гэрээнд заасан хугацаанд эхлээгүй байна. Үүнд:

- "Цагаандэл Уул" хилийн боомт нээх, авто зам барихыг эсэргүүцсэн орон нутгийн иргэдийн эсэргүүцэл;
- Цар тахал-КОВИД 19 /"Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим" НҮТББ-ын 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 02/701 дугаар "Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ/;
- 2022 онд Ерөнхий сайд Өмнөговь аймагт ажиллаж, Даланзадгад хотод иргэдтэй хийсэн уулзалт дээр "Цагаандэл Уул" хилийн боомт, авто замын асуудлыг эргэн харах талаар мэдэгдсэн. Улмаар Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэлд Монгол Улсын Ерөнхий сайдын Өмнөговь аймагт ажиллахдаа өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгасан бөгөөд тус төлөвлөгөөний 7 дугаарт "Хилийн "Цагаандэл Уул-Өлзий" боомтын асуудлыг "Өмнийн говийн хөгжлийн зөвлөл"-өөр хэлэлцэн, санал дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулах" гэж туссан. Энэ асуудлыг шийдвэрлэж, "Өмнийн говийн хөгжлийн зөвлөл"-өөр хэлэлцүүлэх талаар тус яамнаас Боомтын сэргэлтийн үндэсний хороонд 2023 оны 02/503, 2024 оны 01/1696, 03/387 дугаар албан бичгүүдийг хүргүүлсэн боловч тодорхой шийдвэр гараагүй байна.

Тус төслийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаар тус яам Засгийн газрын хуралдаанд танилцуулан, Засгийн газрын 2024 оны 108 дугаар тогтоол гарч, концессын гэрээнд холбогдох өөрчлөлт /концессын гэрээнд заасан гэрээний хугацаа, барилга угсралтын ажил эхлэх, дуусах хугацаа, гүйцэтгэлийн баталгааны хугацаа/ оруулах зөвшөөрлийг Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад олгоод байна.